



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 11

Номгон

**Балансаас балансад  
хөрөнгө шилжүүлэх тухай**

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Чандмань-Баянхонгор” ХК-ний үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2014 онд ашиглалтад орсон 55445000 төгрөгийн анхны үнэтэй 9882541,71 төгрөгийн элэгдэл байгуулсан 45562458,29 төгрөгийн үлдэх өртөгтэй Lexus-470 маркийн 85-58 БНХ улсын дугаартай автомашиныг аймгийн Засаг даргын Тамгын газарт, 2014 онд ашиглалтад орсон 6892568,18 төгрөгийн анхны үнэтэй 1665704,03 төгрөгийн элэгдэл байгуулсан 5226864,15 төгрөгийн үлдэх өртөг бүхий хүүхдийн тоглоомын бүрдлийг Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгт тус тус балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Шилжүүлсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийхийг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

16161